

СОНГОН ШАЛГАРУУЛАЛТАД ОРОЛЦОХ УРИЛГА

Он, сар, өдөр: 2022.06.17

Сонгон шалгаруулалтын нэр: Дулааны станцын SHF14-1.25/150/70 маркын зуух №3 галын хотлын нүүр болон арын хэсгийн тоосгон өрлөг дулаалгыг шинэчлэн засварлах ажил.

Сонгон шалгаруулалтын дугаар: EGD-2022/89

“Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт” ХХК нь “Чингис хаан” Олон улсын нисэх буудлын үйл ажиллагаанд шаардлагатай Дулааны станцын SHF14-1.25/150/70 маркын зуух №3 галын хотлын нүүр болон арын хэсгийн тоосгон өрлөг дулаалгыг шинэчлэн засварлах зорилгоор битүүмжилсэн иж бүрэн санал ирүүлэхийг урьж байна.

1. Сонгон шалгаруулалтад оролцохыг хүссэн эрх бүхий оролцогч нь энэхүү урилгад заасан холбоосоор Захиалагчаас ажлын өдрүүдэд 09:00-15:00 цагийн хооронд нэмэлт мэдээлэл авч болно.
2. Сонирхсон оролцогч нь Захиалагчид бичгээр эсхүл цахим шуудангаар хүсэлт гаргаж, 55,000 (тавин таван мянга) (НӨАТ орсон) төгрөгтэй тэнцэх хураамжийг эргэн төлөгдөхгүй нөхцөлтэйгөөр төлснөөр Монгол хэл дээр бэлтгэгдсэн Сонгон шалгаруулалтын баримт бичгийг цаасаар эсхүл .pdf өргөтгөлтэй файл хэлбэрээр худалдан авч болно. Төлбөрийг Захиалагчийн **Голомт** банкин дах **8125100892** тоот дансанд шилжүүлж, төлбөрийн баримтыг хүсэлтийн хамт хүргүүлнэ.

**Цахим шуудангаар илгээсэн хүсэлт ирээгүй, хугацаа хоцорч ирсэн, төлбөрийн баримт хаягдсан, баримт бичиг тодруулга хугацаа хоцорч хүргээгдсэнтэй холбоотойгоор Захиалагч ямар нэг хариуцлага хүлээхгүй.*

3. Сонгон шалгаруулалтанд ирүүлэх саналаа 2022 оны 7 дугаар сарын 4-ний 12:30 цагт эсхүл түүнээс өмнө урилгад заасан хаягаар ирүүлнэ. Хугацаа хоцорсон саналыг хүлээн авахаас татгалзана. Сонгон шалгаруулалтад ирүүлсэн саналуудыг Чингис хаан Олон улсын нисэх буудлын Захиргааны барилгын 2 давхар 201 тоотод 2022 оны 7 дугаар сарын 4-ний 13:00 цагт бүртгэж, нийтэд мэдээлэх ба сонгон шалгаруулалтад оролцогчид, тэдгээрийн төлөөлөл, сонирхсон бусад этгээд оролцох эрхтэй.
4. Санал бэлтгэх эсхүл хүргэхтэй холбоотойгоор сонгон шалгаруулалтад оролцогчийн зүгээс гаргасан аливаа зардлыг Захиалагч хариуцахгүй.
5. Ирүүлсэн саналуудыг нээх, үнэлэх, гэрээ байгуулах эрх олгохдоо Сонгон шалгаруулалтын баримт бичигт заасныг дагаж мөрдөнө.

“Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт” ХХК

Хаяг: Монгол улс, Төв аймаг, Сэргэлэн сум, 4-р баг, Эрдэнэ-Уул 41090, Тахилт толгой

Холбоо барих утас, цахим шуудан: [71287422, procurement-2@nubia-llc.mn]